



# ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ДААТГАЛЫН ГАРЫН АВЛАГА



УЛААНБААТАР ХОТ 2014 ОН

АГУУЛГА

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, ЗОРИЛГО .....	4
2. ДААТГАЛЫН ҮНДСЭН ЗАРЧМУУД	
3. ҮНДСЭН ЗОХИЦУУЛАЛТ	
3. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД .....	5
4. ДААТГАЛЫН ЭРСДЛҮҮД .....	9
5. ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД.....	10
6. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ .....	10
6.1 ОРОН СУУЦ - АМИНЫ ОРОН СУУЦ, НИЙТИЙН ОРОН СУУЦ, ОФФИС	
6.2 ҮЙЛЧИЛГЭЭ - ЗОЧИД БУУДАЛ, ДЭЛГҮҮР , РЕСТОРАН, ПАБ , КАФЕ	
6.3 ҮЙЛДВЭР - ХӨНГӨН ҮЙЛДВЭР, ХҮНД ҮЙЛДВЭР ,УУЛ УУРХАЙ, АГУУЛАХ	
7. ХУРААМЖ ТООЦОХ ХҮЧИН ЗҮЙЛС .....	13
8. ДААТГАЛЫН ХУРААМЖ ТООЦОХ ЗАРЧИМ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
9. ХУРААМЖИЙН ХӨНГӨЛӨЛТ, НЭМЭЛТ ТООЦОХ.....	15
10. НЭМЭЛТ ХАМГААЛАЛТ .....	15
11. АСУУЛГЫН ХУУДАСНЫ ЗАГВАР .....	15
12. НӨХӨН ТӨЛБӨРИЙН МАЯГТЫН ЗАГВАР .....	19
13. НӨХӨН ТӨЛБӨРИЙН МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭЛТ.....	20
14.СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЗАГВАР	
15.АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ	
16.НӨӨЦ САНГИЙН ТООЦООЛОЛ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
17.ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ .....	26

Гарын авлагыг бэлтгэсэн:

Б.Анхбаяр	Номин Даатгал ХХК
З.Ариунцэцэг	Монре Даатгал ХХК
Ш.Байгалмаа	Моннис Даатгал ХХК
Б.Булган	Монгол Даатгал ХХК
Д. Мөнхбилэг	МИД төсөл
Ж.Мядагноров	СЗХ
М.Туул	Мандал Даатгал ХХК
Т.Оюунбат	МИД төсөл
Д.Чулуунцэцэг	Тэнгэр Даатгал ХХК

## НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлага нь /цаашид “гарын авлага” гэх /Монгол улсын даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй ердийн даатгалын компаниудын боловсон хүчний чадавхийг сайжруулах, мэргэшүүлэх, тэдгээрийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах ажлын багаж хэрэгсэл болгон ашиглах зорилготой юм. Гарын авлагыг хэрэглэж дадсанаар даатгалын эрсдлийг зөв тодорхойлох, эрсдлийн үнэлгээг зөв хийх, даатгалын хураамжийг зөв тооцож сурах давуу талтай юм.

2013 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 2,8 их наяд төгрөгийн үл хөдлөх хөрөнгө бүртгэгдсэн бөгөөд эдгээрийн 10-15 орчим хувь нь даатгалтай байдаг гэсэн судалгаа гарсан байна. Бид даатгалын компаниудын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлснээр дээрх даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх, эрсдлийг зөв удирдаж сурах, даатгалын хураамжийг өсгөхөд чухал нөлөөтэй юм.

Одоогоор даатгалын компаниудын ашиглаж буй эрсдлийн үнэлгээ хийх, хураамж тооцох аргачлал нь компани тус бүрийн ажилтнуудын туршлага, ур чадвараас шууд хамааралтай байгаа бөгөөд бид энэхүү гарын авлагыг ашигласнаар мэргэжлийн түвшинд ажиллаж, даатгуулагчид өөрсдийн хамгийн сайн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдэж байгаа юм.

Үл хөдлөх хөрөнгийн даатгалын гарын авлага нь Монгол улсын хэмжээнд дагаж мөрдөж буй хууль, эрхзүйн зохицуулалтуудын хүрээнд даатгалын зүйлийг ангилж тодорхойлон, даатгагч даатгуулагчийн хооронд хийгдэх даатгалын гэрээний стандарт нөхцлийг агуулсан, даатгалын эрсдэл болон хасалтуудыг зөв тодорхойлж тухайн эрсдэлд тохирсон хураамжийг нөлөөлөх хүчин зүйлийн дагуу тооцоолсон, даатгуулагчаас авах асуулгын хуудас болон нөхөн төлбөрийн маягтийг агуулсан андеррайтинг хийх системчилсэн аргачлалуудыг агуулсан.

## 2. ДААТГАЛЫН ҮНДСЭН ЗАРЧМУУД

- ❖ Нөхөн төлбөрийн зарчим (**Indemnity**): даатгалын гэрээний дагуу даатгуулагчид тохиролцсон эрсдэл, аюулын улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх.
- ❖ Даатгалын сонирхолтой байх зарчим (**Insurable Interest**): Даатгуулагч өөрийн гэр байшиндаа л даатгалын сонирхолтой байхаас хөршийнхөө байшинд бус гэсэн зарчим юм. Даатгуулагч даатгалын хамаарах асуудлаар хууль эрх зүйн зөв харилцаатай байх. Энэ нь гэнэтийн ослын даатгалын хувьд хууль ёсны өв залгамжлал хүртэх эрх бүхий этгээдийг нэрлэж өгөх. Даатгуулагчийн гэр бүлийн гишүүдийг ирээдүйд бий болох санхүүгийн эрсдлээс хамгаалах үүднээс даатгуулах.
- ❖ Шууд шалтгааны зарчим (**Proximate cause**): Даатгуулагчийн даатгалын зүйлд эрсдэл учирсан анхдагч шалтгааныг илрүүлэх. Тухайн эрсдэл нь шууд буюу анхдагч эрсдэл байх ёстой.
- ❖ Туйлын үнэнч шударга байх зарчим (**Utmost good faith**): Даатгалын гэрээ байгуулагч талууд нь туйлын үнэнч шударга байх тухай бөгөөд гэрээнд оролцогч талуудын аль алинд ноогддог үүрэг юм. Даатгуулагч нь даатгалын гэрээ байгуулах эсвэл хүсэлт гаргах өргөдөл бөглөхдөө даатгуулах зүйлийнхээ талаар бүрэн гүйцэд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн даатгагч эрсдлийг хүлээн авах эсэх, ямар хэмжээний хамгаалалт үзүүлэх эсэхээ шийддэг. Даатгагчийн хувьд даатгуулагчдад үйл ажиллагааны болон санхүүгийн хувьд ил тод нээлттэй, тунгалаг байх үүрэгтэй.
- ❖ Контрибуци зарчим (**Contribution**): энэ зарчим даатгалын компаниудын хооронд гарч ирдэг зарчим юм. Даатгуулагч өөрийн эд хөрөнгөө хэд хэдэн даатгуулагчид зэрэг даатгуулах, нөхөн төлбөрийг тэдгээр даатгагчаас авах хандлагатай байдаг учраас даатгалын компаниуд хоорондоо мэдээлэл, тооцооны харилцаатай байх гэсэн зарчим юм.
- ❖ Суброгаци зарчим (**Subrogation**): Даатгуулагчийн эд хөрөнгө амь насанд эрсдэл учирч түүнд нь гуравдагч этгээд буруутай бол даатгуулагчийн хохирлыг түргэн шуурхай барагдуулах ба гаргасан нөхөн төлбөр ба түүнтэй холбогдон гарах зардлын нийлбэрээр буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх зарчим юм.
- ❖ Маргаан шийдвэрлэх зарчим (**Arbitration**): Даатгал нь мөнгөтэй холбоотой харилцаа учраас маргаан үл ойлголцол гарах нь элбэг. Даатгуулагч, даатгагчийн хооронд маргааныг шийдвэрлэх нэг арга нь маргааныг шүүхээр бус дундын гуравдагч этгээдийн шийдвэрийг хүлээн авч шийдвэрлэгэдэг хуулийн арга техник юм.

## ГУРАВ. ҮНДСЭН ЗОХИЦУУЛАЛТ

Үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээнд оруулж, тооцох ёстой хэд хэдэн үндсэн зохицуулалтууд байдаг бөгөөд дараах байдлаар тооцно. Үүнд:

- Даатгалын гэрээний хугацаа  
Үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээ нь 12 сар хүртэлх хугацаагаар байгуулагдана. Хэрвээ 12 сараас бага хугацаагаар байгуулагдах тохиолдолд хувь тэнцүүлэх зарчмаар тооцож дээр нь 15%-иар нэмэгдүүлэн тооцно.
- Даатгалын үнэлгээг нөхөн сэргээх  
Даатгалын үнэлгээ гэрээний явцад өссөн тохиолдолд даатгалын хураамжийг тооцохдоо хувь тэнцүүлэх зарчмаар тооцно. Үнэлгээ буурсан тохиолдолд даатгалын хураамжийг тооцохдоо хувь тэнцүүлэх зарчмаар тооцож, 15%-иар нэмэгдүүлэн тооцно. Даатгуулагч нөхөн төлбөр авсан тохиолдолд олгосон нөхөн төлбөрийн хэмжээгээр даатгалын үнэлгээг нөхөн сэргээнэ. Үнэлгээг нөхөн сэргээхдээ авсан нөхөн төлбөрийг дүнг гэрээний үлдсэн хугацаанд хувь тэнцүүлэх зарчмаар хураамжийг төлж сэргээнэ.
- Даатгалын гэрээ цуцлах

- a. Даатгуулагчийн хүсэлтээр даатгалын гэрээг дараах 2 байдлаар цуцлана.
  1. Даатгалын гэрээг цуцлахдаа үлдсэн хугацаанд ногдох хураамжийг хувь тэнцүүлэх зарчмаар тооцож, 15%-иар нэмэгдүүлэн тооцно.
  2. Даатгуулагч ижил зориулалтаар ашигладаг өөр төрлийн хөрөнгийг өмнөх гэрээтэй төстэй эрсдлээс даатгуулсан тохиолдолд хувь тэнцүүлэх зарчмаар үлдсэн хугацаанд ногдох хураамжийг буцаан олгоно.
- b. Даатгагчийн хүсэлтээр цуцлахдаа даатгалын гэрээний үлдсэн хугацаанд ногдох хураамжийг хувь тэнцүүлэх зарчмаар олгоно.

## ДӨРӨВ. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД

### НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр нэг талаас даатгуулагч нь энэхүү гэрээний хавсралтанд дурдсан даатгалын зүйлийг даатгуулж даатгалын хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг даатгуулагчид нөхөн төлөх харилцааг зохицуулна.
- 1.2 Хоёр тал энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай Монгол улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө

### ХОЁР.ХЭРЭГЛЭГДЭХ НЭР, ТОМЪЁОЛОЛ

- 2.1 Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 2.1.1 **даатгагч** гэж Даатгалын тухай Монгол Улсын хуулийндагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монгол улсын хуулийн этгээд болох Даатгал ХХК-ийг ;
  - 2.1.2 **даатгуулагч** гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан этгээдийг;
  - 2.1.3 **даатгалын зүйл** гэдэгт эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхлыг;
  - 2.1.4 **даатгалын эрсдэл** гэдэгт даатгалд хамрагдсан зүйлд хохирол учруулж болох нөхцөл, орчныг;
  - 2.1.5 **даатгалын тохиолдол** гэж даатгуулсан зүйлд даатгалын эрсдлийн улмаас учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
  - 2.1.6 **даатгалын хураамж** гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
  - 2.1.7 **даатгалын нөхөн төлбөргөж** гэрээний дагуу даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;
  - 2.1.8 **даатгалын үнэлгээгэж** даатгуулж байгаа эд хөрөнгийн болон эдийн бус ашиг сонирхлын мөнгөн илэрхийллийн хэмжээг;
  - 2.1.9 **өөрийн хүлээх хариуцлагын хэмжээгэж** даатгалын тохиолдлоос үүссэн хохиролд даатгагчийн олгох нөхөн төлбөрөөс хасагдах хэмжээ;
  - 2.1.10 **хүндэтгэн үзэх шалтгаан** - форс мажор, эсвэл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээг хүчин төгөлдөр болгох, гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгах, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах боломжгүй нөхцөл байдал үүссэн үндэслэлүүд байна;
  - 2.1.11 **форс мажор** - давагдашгүй хүчин зүйл буюу гэрээний нөхцөл биелэгдэх боломжгүй үр дүн үүссэн онцгой ба дийлдэшгүй нөхцөл байдлыг хэлэх ба энэ нь бэрхшээлтэй төдийгүй үнэмлэхүй байх ёстой ба үүнд байгалийн гамшиг, дайн, зэвсэгт бослого, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэрийн улмаас үүссэн нөхцөл байдлыг оруулж ойлгоно;

### **ГУРАВ.ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1 Даатгагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
  - 3.1.1 Энэ хуулийн гэрээний нөхөн төлбөр заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;
  - 3.1.2 Даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;
  - 3.1.3 Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
  - 3.1.4 Даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;
  - 3.1.5 Даатгалын баталгааг гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид олгох;
  - 3.1.6 Даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;
  - 3.1.7 Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаархи мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;
  - 3.1.8 Даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;
  - 3.1.9 Даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;
  - 3.1.10 Гэрээний хугацаанд даатгуулагч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдвол түүний эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
  - 3.1.11 Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу санхүүгийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх.

### **ДӨРӨВ. ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1 Даатгуулагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
  - 4.1.1 Даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
  - 4.1.2 Даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
  - 4.1.3 Даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;
  - 4.1.4 Даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгагчид төлөх;
  - 4.1.5 Даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх;
  - 4.1.6 Даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх.

### **ТАВ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- 5.1 Даатгагч нь хууль болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу энэ хуулийн 5.4-т заасан баримтыг үндэслэн даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.
- 5.2 Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд шууд олгож болно.
- 5.3 Даатгуулагч нас барсны дараа даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын нөхөн төлбөрийг түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.
- 5.4 Даатгалын нөхөн төлбөрийг дараахь баримтыг үндэслэн олгоно:
  - 5.4.1 Даатгуулагчийн өргөдөл;
  - 5.4.2 Даатгалын баталгааны эх хувь;
  - 5.4.3 Учирсан хохирлын тухай хохирол үнэлэгчийн бичгээр гаргасан дүгнэлт, акт материал;
  - 5.4.4 Шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт.
- 5.5 Даатгагч дараахь үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзаж болно:
  - 5.5.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;

- 5.5.2 Даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 5.5.3 Даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;
- 5.5.4 Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
- 5.5.5 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 5.6 Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.
- 5.7 Даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

### **ЗУРГАА. ДААТГАЛЫН ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**

- 6.1 Даатгалын гэрээний хугацаа дуусаагүй байхад нэг тал нь гэрээ цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 3 сарын дараа цуцалж болно.
- 6.2 Даатгалын гэрээг нэг жилээс дээш хугацаагаар сунгах нөхцөлтэйгээр байгуулсан тохиолдолд талууд гэрээний хугацааг дуугүй хүлээн зөвшөөрөх замаар сунгах, даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцлахгүй байх тохиролцоо хүчин төгөлдөр бус байна. Даатгуулагч гэрээг цуцлахдаа энэ гэрээний 6.1-д заасан хугацааг баримтлах үүрэгтэй.
- 6.3 Даатгагч даатгалын хураамжийг нэмэгдүүлсэн тохиолдолд даатгуулагч нь 1 сарын дотор гэрээг цуцалж болно.

### **ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

- 7.1 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 7.2 Гэрээ байгуулах болон гэрээний хугацаанд даатгалын тохиолдол бий болох, даатгалын эрсдэл нэмэгдэхэд нөлөөлөхүйц хүчин зүйл үүссэнтэй холбогдуулан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах, мэдэгдэл хүргүүлэх, үүсэх үр дагавартай холбогдсон асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:
  - 7.2.1 Даатгуулагч даатгуулах тухай хүсэлтээ даатгагчид гаргаснаас хойш гэрээ байгуулах хүртэлх хугацаанд даатгалын тохиолдол болоход нөлөөлөхүйц хүчин зүйл үүссэн бол энэ тухай гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө даатгагчид заавал мэдэгдэх;
  - 7.2.2 Даатгагч энэхүү мэдэгдлийг үндэслэн нэмэлт хураамж төлөхийг даатгуулагчаас шаардах;
  - 7.2.3 Гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах тухай бүх мэдэгдэл, өргөдөл, хүсэлтийг талууд хамгийн сүүлд мэдэгдсэн хаягаар харилцан илгээнэ. Хаягийн өөрчлөлтөө мэдэгдээгүйн улмаас үүсэх хариуцлагыг талууд нэгнийхээ өмнө хүлээхгүй;
  - 7.2.4 Гэрээний аль нэг тал нөгөө талаас гэрээнд өөрчлөлт оруулах санал бүхий бичиг баримтыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хариу ирүүлээгүй, эсхүл ямар нэгэн хэлбэрээр мэдэгдээгүй бол саналыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 7.3 Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг талууд харилцан тохиролцож гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба үйлчлэх хугацааг тусгайлан зааж болох бөгөөд хугацааг заагаагүй тохиолдолд гэрээний хугацаатай адил байна.

### **НАЙМ. ДҮГНЭЛТ**

- 8.1 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжид заагдсан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- 8.2 Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа маргаантай асуудлыг талууд харилцан тохиролцоо зарчмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд хэлэлцээрийн аргаар зохицуулж эс чадвал шүүхэд гомдол гарган шийдвэрлүүлнэ.

### **ЕС. Эд хөрөнгийн даатгал**

- 9.1 Даатгалын зүйл, түүний үнэлгээ ба даатгалын хураамжийн хэмжээг дор дурдсан байдлаар тодорхойлно. Үүнд:



№	Даатгалын зүйл	Даатгалын үнэлгээ	Хураамж
	Хавсралт № 1		
	НИЙТ		

- 9.2 Даатгуулагч даатгалын гэрээ батлагдсан өдрөөс хойш ажлын гурав хоногт багтаан даатгалын хураамжийг Даатгагчид төлнө.
- 9.3 Даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд нь төлөөгүй бол даатгагч даатгуулагчийн бичгээр өгсөн хүсэлтийг үндэслэн хураамж төлөх 15 хоногийн нэмэлт хугацаа тогтоож болох бөгөөд энэ хугацаа хэтэрсэн үед даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.
- 9.4 Даатгалын эрсдэл
- 9.4.1 Үндсэн багц эрсдэл. Үүнд:
- 9.4.1.1 Бүх төрлийн байгалийн эрсдэлүүд
- 9.4.1.2 Бүх төрлийн гал түймэр, дэлбэрэлийн эрсдэлүүд
- 9.4.1.3 Цахилгаан эрчим хүчний хэлбэлзэл, хэт ачаалал, тусгаарлагчийн гэмтлийн эрсдэл
- 9.4.1.4 Сантехникийн шугам хоолойн ил болон далд эвдрэл гэмтэл, түүнээс үүдэх эрсдэл
- 9.4.2 Нэмэлт эрсдэл. Үүнд:
- 9.4.2.1 Хулгай, дээрэм, гуравдагч этгээдийн санаатай болон санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас учирч болзошгүй эрсдэл

### АРАВ. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 10.1 Энэхүү гэрээ нь 2014/00/00-ны өдрийн 00 цагаас 2015/00/00-ний өдрийн 24.00 цаг хүртэл хүчин төгөлдөр байна.
- 10.2 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 10.2.1 хууль болон даатгалын гэрээгээр тогтоосон хугацаа дууссан;
- 10.2.2 даатгагч эсхүл даатгуулагч дампуурсан, татан буугдсан;
- 10.2.3 шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тогтоосон;
- 10.2.4 даатгагдсан хөрөнгө шүүхийн шийдвэрээр хураагдсан;
- 10.2.5 даатгалын хугацааг гэрээнд зааснаас өмнө дуусгавар болгохоор 2 тал то
- 10.3 Гэрээ дуусгавар болсон тохиолдолд талууд гэрээг дүгнэж, сунгах эсэхийг шийдвэрлэнэ. Гэрээний хугацаа дуусмагц талууд гэрээг цуцлах санал тавиагүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсээр байгаа бол гэрээг анх заасан хугацаагаар сунгагдсанд тооцно.

### ТАВ. ДААТГАЛЫН ЭРСДЛҮҮД

#### Үндсэн эрсдэл

1. Байгалын эрсдэл
  - 1.1 *хүчит салхи, цасан болон шороон шуурга*
  - 1.2 *ширүүн мөндөр, аадар бороо, аянга цахилгаан, үер усны аюул*
  - 1.3 *газар хөдлөлт*
  - 1.4 *хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт*
  - 1.5 *галт уулын дэлбэрэлт*
2. Галын эрсдэл
  - 2.1 *ахуйн гал түймэр*
  - 2.2 *дэлбэрэлт, тэсрэлт*
3. Цахилгааны эрсдэл
  - 3.1 *цахилгааний хэлбэлзэл*

3.2 цахилгааны хэт ачаалал

4. Сантехникийн эрсдэл

4.1 Ус алдах болон хөлдөлт

4.2 Ус чийгний нөлөөлөл

**Нэмэлт эрсдэл**

5. Ахуйн эрсдэл

/Даатгалын зүйл биет зүйлд цохиулах, дарагдах, шүргүүлэх/

6. Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлээс учрах эрсдэл

7. Хулгай, дээрмийн эрсдэл

/Хулгай, дээрэм болон түүний үр дагавар/

**ЗУРГАА. ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД**

1. Даатгалын гэрээнд тусгаагүй эрсдэл, шалтгааны улмаас даатгалын зүйлд учирсан хохирол
2. Даатгуулагч даатгал хийлгэхдээ худал хуурамч мэдүүлэг мэдүүлэг өгсөн, нөхөн төлбөр нэхэмжлэхдээ хуурамч бичиг баримт бүрдүүлсэн болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай учирсан хохирлыг нотлох баримтыг бүрэн бүрдүүлэн Даатгагчид өгөөгүй тохиолдолд
3. Даатгуулагчийн хууль бус үйлдэл болон санаатай үйлдлийн үр дагавар, хохирол буюу даатгалын тохиолдол болох нөхцөл орчныг бүрдүүлсэн;
4. Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсон үед Даатгагчид мэдэгдэж, зөвшөөрөл авалгүйгээр хохирлыг барагдуулах аливаа шийдвэр гаргасан болон буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн
5. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна учирсан хохирол;
6. Даатгалын гэрээнд заасан даатгуулагчийн өөрийн хариуцах хэсэг
7. Дайн байлдаан, үймээн, самуун, бослого, хөдөлгөөн, нийгмийн эмх замбараагүй байдал, төрийн эргэлт, террорист үйл ажиллагааны үр дагаварууд болон мин, тропед, бөмбөг эсвэл бусад тэсрэх бодисоос үүдэлтэй хохирол.
8. Цацраг идэвхт, хими, химийн хорт, биологи, био-химийн бодис, түүний бохирдолт болон үүдсэн үр дагавар, түлш болон түүний шаталтаас ялгарсан хог хаягдлын шууд болон шууд бус, үр дагаврын чанартай үйлчлэл.
9. Засгийн Газрын эсвэл шүүх, шүүхийн шийдвэр биелүүлэх газар, олон нийтийн байгууллагын шийдвэрээр хураагдсан хөрөнгө
10. Үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын стандарт горимыг зөрчсөн зэргээс үүссэн хохирол
11. Учирсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн болон санхүүгийн алдагдал
12. Ургамал, цэцэг, мод, мал амьтанд, хүний эрүүл мэнд, амь насанд учирсан хохирол

**ДОЛОО. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ**

7.1 Орон сууц

6.1.1 Амины орон сууц

6.1.2 Нийтийн орон сууц

6.1.3 Оффис

6.2 Үйлчилгээ

6.2.1 Зочид буудал

6.2.2 Дэлгүүр

6.2.3 Ресторан, паб, кафе

### 6.3 Үйлдвэр

#### 6.3.1 Хөнгөн үйлдвэр

#### 6.3.2 Хүнд үйлдвэр

#### 6.3.3 Уул уурхай

#### 6.3.4 Агуулах

## ДОЛОО. ХУРААМЖ ТООЦОХ ХҮЧИН ЗҮЙЛС

### 7.1 Орон сууцны хураамж тооцох хүчин зүйлс – Амины орон сууц, Нийтийн орон сууц, Оффис

#### 7.1.1 Үндсэн хүчин зүйлүүд

- Барилгын хийц
  - Бүрэн цутгамал төмөр бетон
  - Карказ – багана, дам нуруу, хучилт,
  - Металл хийц
  - Тоосгон
  - Модон
- Байршил
  - Газар хөдлөлтийн бүс
  - Газарзүйн байршил
- Барилгын чанар
  - Зураг төслийн дагуу хийгдсэн эсэх
  - Цахилгааны утасны материал
  - Сантехник
  - Агааржуулалтын систем
  - Дотоод засал
- Ашигласан жил
  - 0-3 жил
  - 3-6 жил
  - 6-10 жил
  - 11-20 жил
  - 21-30 жил
  - 30-аас дээш жил

#### 7.1.2 Хураамжинд нөлөөлөх нэмэлт хүчин зүйс

- Харуул хамгаалалт
  - Хамгаалалтын дохиолол
  - Харуул хамгаалалтын үйлчилгээтэй эсэх
- Галын хамгаалалт
  - Галын дохиолол, бороожуулагч
  - Галын гарц, схем зураг
  - Гал унтраагуур

### 7.2 Үйлчилгээний зориулалт бүхий үл хөдлөх хөрөнгийн даатгалын хураамж тооцох хүчин зүйлс – Зочид буудал, ресторан, дэлгүүр, худалдааны төв, паб кафе

#### 7.2.1 Үндсэн хүчин зүйлүүд

- Баригын хийц
  - Бүрэн цутгамал төмөр бетон
  - Карказ – багана, дам нуруу, хучилт,
  - Металл хийц
  - Тоосгон

- Модон
- Байршил
  - Газар хөдлөлтийн бүс
  - Газарзүйн байршил
- Барилгын чанар
  - Зураг төслийн дагуу хийгдсэн эсэх
  - Цахилгааны утасны материал
  - Сантехник
  - Агааржуулалтын систем
  - Дотоод засал
- Ашигласан жил
  - 0-3 жил
  - 3-6 жил
  - 6-10 жил
  - 11-20 жил
  - 21-30 жил
  - 30-аас дээш жил

#### 7.2.2 Хураамжинд нөлөөлөх нэмэлт хүчин зүйс

- Харуул хамгаалалт
  - Хамгаалалтын дохиолол
  - Харуул хамгаалалтын үйлчилгээтэй эсэх
- Галын хамгаалалт
  - Галын дохиолол, бороожуулагч
  - Галын гарц, схем зураг
  - Гал унтраагуур

### **7.3 Үйлдвэрийн зориулалт бүхий үл хөдлөх хөрөнгийн даатгалын хураамж тооцох хүчин зүйлс- Хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэр, уул уурхай, агуулах**

#### 7.2.3 Үндсэн хүчин зүйлүүд

- Баригын хийц
  - Бүрэн цутгамал төмөр бетон
  - Карказ – багана, дам нуруу, хучилт,
  - Металл хийц
  - Тоосгон
  - Модон
- Байршил
  - Газар хөдлөлтийн бүс
  - Газарзүйн байршил
- Барилгын чанар
  - Зураг төслийн дагуу хийгдсэн эсэх
  - Цахилгааны утасны материал
  - Сантехник
  - Агааржуулалтын систем
  - Дотоод засал
- Ашигласан жил
  - 0-3 жил
  - 3-6 жил
  - 6-10 жил
  - 11-20 жил

- 21-30 жил
- 30-аас дээш жил

#### 7.2.4 Хураамжинд нөлөөлөх нэмэлт хүчин зүйс

- Харуул хамгаалалт
  - Хамгаалалтын дохиолол
  - Харуул хамгаалалтын үйлчилгээтэй эсэх
- Галын хамгаалалт
  - Галын дохиолол, бороожуулагч
  - Галын гарц, схем зураг
  - Гал унтраагуур

### 8. ДААТГАЛЫН ХУРААМЖ ТООЦОХ ЗАРЧИМ

#### 8.1 Хураамж тооцох арга

Ашигтай ажиллахын тулд даатгалын компаниуд нь доорх зардлыг хураамжиндаа багтаах шаардлагатай:

***Цэвэр хураамж+үйл ажиллагааны зардал+зуучлагчийн шимтгэл/маркетингийн зардал+тооцооллын алдааны засвар зардал+бусад зардал+ашиг***

**Цэвэр хураамж нь нийт хураамжийн нэг хэсэг бөгөөд бусад зардал болон ашигийг оруулаагүй ирээдүйд учирч болох нөхөн төлбөрийн хэмжээг хэлдэг.**

Даатгалын компаний андеррайтерууд цэвэр хураамжийг доорх томъёоллоор тооцоолно:

**Цэвэр хураамж= ирээдүйд учрах дундаж нөхөн төлбөрийн зардал\*ирээдүйд учрах нөхөн төлбөрийн давтамж**

***(Цэвэр ашиг)      X      (Эрсдлийн хамаарал)***

8.1.1 Цэвэр хураамжийг тооцох 2 арга байдаг:

1. *Туршлагад үндэслэсэн арга* – тухайн бүтээгдэхүүнд сүүлийн хэдэн жилийн хангалттай мэдээлэл байгаа бол, андеррайтерууд учирсан дундаж нөхөн төлбөрийн зардалыг тооцоолж болно.

***Ирээдүйд учрах дундаж нөхөн төлбөрийн зардал=Нийт нөхөн төлбөрийн хэмжээ/Нийт нөхөн төлбөрийн тоо***

2. *Үнэлгээний арга* – эд хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл ойролцоо төрлийн эд хөрөнгийн зах зээлийн үнэн дээр тулгуурлан андеррайтерууд учирч болох дундаж нөхөн төлбөр болон хохирлыг тодорхойлж болно. Даатгагч энэхүү аргаар эд хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл даатгалын үнэлгээг цэвэр хураамжийг тооцоходоо ашиглаж болно.

8.1.2 Ирээдүйд учрах нөхөн төлбөрийн давтамжийг тооцоолоходоо бүтээгдэхүүний эрсдлийн хамаарлыг авч үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, андеррайтерууд нь зөвхөн тэр эрсдлийн туршлага дээр үндэслэн нэгж эрсдлийн хураамжийг тооцож чадахгүй учир андеррайтерууд нь эрсдлийн шинж чанар болон хүчин зүйлүүдийг ашиглах хэрэгтэй. Ингэснээр, эрсдлийг тооцоходоо хураамжийн ангилалуудыг

ашиглан тооцоолох бөгөөд энэ нь ижил төстэй боломжит хохирол учирч болох эрсдлүүдийг бүлэглэх мөн бүлэг доторх ялгаатай боломжит хохирлуудыг илэрхийлэх өөр өөр хураамжийн тооцоог гараар бодож өгч нэмэж тооцно. Эдгээр эрсдлийг хамааралтай болон ялгаатай талаар нь 4 шалгуураар бүлэглэж болж байна.

- Статистикийн мэдээнд тулгуурласан шалгуур – андеррайтерууд нь боломжит хураамж тооцох сонголтуудын үнэн бодит байдлыг бататгахад нь доорх статистикт тулгуурласан шалгуурыг ашиглана:
  - Статистикийн мэдээний ач холбогдол
  - Ижил төстэй байдал
  - Бодитой байдал
- Үйл ажиллагааны шалгуур -
  - Зорилготой чиглэсэн
  - Үйл ажиллагаа явуулахад үнэтэй биш
  - Хянаж болохуйц
- Нийгмийн шалгуур – тодорхой нэг эрсдлийг хураамж тооцох өөр нэгэн нөхцөл болгон ашиглахдаа олон нийтийн хэрхэн хүлээж авч байгааг тодорхойлохдоо доорх зүйлсийг шалгуур болгоно:
  - Худалдан авах чадамж
  - Шалтгаант холбоо
  - Удирдах боломж
  - Хувийн шалтгаан
- Хуулийн шалгуур – андеррайтерууд юуг хэрэглэж болох болохгүй гэдгийг мэдэж байхын тулд хууль болон журмуудыг сайн мэдэж байх шаардлагатай.

*Ирээдүйд учирч болох нөхөн төлбөрийн давтамж= нөхөн төлбөрийн тоо/нийт нөхөн төлбөрийн тоо*

## 8.2 Андеррайтингийн харьцаа

1. *Хохирлын харьцаа = нийт хохирол / даатгалын хураамж*
2. *Андеррайтингийн хохирлын харьцаа = учирсан нөхөн төлбөр / орлогод тооцсон хураамж*
3. *Хосолсон харьцаа = (Нийт хохирол + зардал) / Нийт хураамж*
4. *Андеррайтингийн зардал = Андеррайтингийн нийт зардал / даатгалын хураамж*
5. *Удирдлагын зардлын харьцаа = Удирдлагын зардал / орлогод тооцсон хураамж*
6. *Нөөцийн харьцаа = Сунгасан гэрээний тоо / боломжит сунгах гэрээний тоо*

## 8.3 Хураамж тооцох шинжилгээнд шаардлагатай статистикийн мэдээлэл – нөхөн төлбөрийн мэдээлэл

- Хохирлын огноо
- Мэдээлсэн огноо
- Нөхөн төлбөр төлсөн хэмжээ болон огноо
- Шийдвэрлэгдээгүй нөхөн төлбөрийн хэмжээний тооцоолол
- Эрсдлийн төрөл (нөхөн төлбөр хүсч буй зүйл заалт)
- Нөхөн төлбөрийн төрөл
- Нөхөн төлбөрт нөлөөлж буй хураамж тооцох хүчин зүйлс

Бүх нөхөн төлбөрийн мэдээ нь хураамж тооцох хүчин зүйлүүдийн дагуу хадгалагдсан байх ёстой.

## 9. ХУРААМЖИЙН ХӨНГӨЛӨЛТ, НЭМЭЛТ ТООЦОХ

Тухайн үл хөдлөх хөрөнгийн даатгалын хураамжийг тооцохдоо дараах зүйлүүдийг харгалзан үзэж хөнгөлөлт үзүүлэх боломжтой юм. Үүнд:

Нөхцөлүүд	
Аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> <li>Хамгаалалтын хашаатай болон хамгаалагч байнгын харуул хамгаалалттай бол хөнгөлөлт үзүүлэх боломжтой.</li> <li>Дохиоллын систем болон цоож хамгаалалтын хэрэгсэл сайтай бол хөнгөлөлт эдлэх боломжтой.</li> </ul>
Галын систем	<ul style="list-style-type: none"> <li>Утаа мэдрэгч болон ус цацруулагч, дулаан мэдрэгч суурилуулсан болон галын аврах гарц сайн, гал унтраах хэрэгсэл бүрэн бүтэн, цаг хугацаанд шинэчлэл хийгдэж байдаг бол хөнгөлөлт үзүүлэх боломжтой.</li> </ul>
Засвар үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>Цахилгаа утасны монтаж сүлжээ сайн бол хөнгөлөлт үзүүлэх боломжтой.</li> <li>Дээврийн хамгаалалт уснаас сайн хамгаалагдсан засвар үйлчилгээ тогтмол сайн хийгддэг болон Сантехникийн шугам сүлжээ шинэчлэл хийгдсэн бол хөнгөлөлт үзүүлэх боломжтой.</li> </ul>
Шинэ баригдсан барилга	<ul style="list-style-type: none"> <li>Шинээр баригдаж ашиглалтанд орсон хөрөнгөд үзүүлэх хөнгөлөлт боломжтой</li> </ul>
Даатгалын түүх	<ul style="list-style-type: none"> <li>Өмнөх даатгалын хугацаанд нөхөн төлбөр аваагүй болон даатгалын тохиолдол гарч байгаагүй бол хөнгөлөлт үзүүлэх боломжтой.</li> </ul>

## 10. НЭМЭЛТ ХАМГААЛАЛТ

1. Даатгалын тохиолдолтой холбогдон гарсан хог хаягдлыг зөөн тээвэрлэх зардал /Олон улсын практикт нийт хохирлын 3%-аас хэтрэхгүй байдаг/
2. Архитектурын зардал/Олон улсын практикт нийт хохирлын 3%-аас хэтрэхгүй байна/
3. Шинжээч болон зөвлөх ажилчдын зардал
4. Түрээсийн алдагдсан орлого
5. Өөр байр түрээслэх зардал
6. Бохирдол болон эвдэрсэн зүйлсийг цэвэрлэх, ачих зардал
7. Даатгалд хамруулаагүй даатгалын зүйлд гарсан нэмэлт өргөтгөлд учирсан хохирол
8. Даатгалын зүйлийн доторх зүйлсийг түр зуур шилжүүлэх зардал

## 11. АСУУЛГЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

### АСУУЛГЫН ХУУДАС

- **Асуулгын хуудасны зорилго** нь даатгуулах зүйлийн эрсдэлийн түвшинг үнэлэх зорилготой бөгөөд даатгалын гэрээний үндэслэл ба салшгүй баримт бичиг юм.

- Даатгалын байгууллага асуулга дахь мэдээллүүдийг боловсруулсны үндсэн дээр үнийн саналыг тооцоолж гаргадаг тул та бүхэн асуулгын **хуудсыг бүрэн бүтэн, үнэн зөв** бөглөх зайлшгүй шаардагатай юм.
- Хэрэв даатгалын байгууллага нь мэдээлэл хангалтгүй гэж үзвэл танаас **нэмэлт мэдээлэл** гаргуулж болох юм.
- Бид таны өгсөн мэдээллийг үндэслэн үнийн саналаа тодорхой хугацаанд хүчинтэй байхаар өгнө.
- Зориудаар **худал мэдээлэл өгөх** болон мэдээллийг **нуун дарагдуулах нь** гэрээ байгуулагдсаны дараа нөхөн төлбөрөөс татгалзах, цаашлаад гэрээ цуцлагдах үндэслэл болж болзошгүй.
- Өгсөн мэдээлэл нь даатгуулсаны дараа өөрчлөгдсөн бол та өөрийн андеррайторт хандаж **мэдээллээ шинэчлэн** өгөх шаардлагатай юм.
- Танд амжилт хүсье.

## 1. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Хуулийн этгээдийн мэдээлэл	Бөглөнө үү	Удирдах ажилчдын мэдээлэл:	Нэр, утас, имэйл
Хуулийн этгээдийн нэр		Гүйцэтгэх захирал	
Байгуулагдсан он		Санхүү эрхэлсэн захирал	
Хуулийн этгээдийн регистр №		Ерөнхий менежер	
Үйл ажиллагааны чиглэл		Даатгал хариуцсан ажилтан	
Үйл ажиллагаа явуулж буй үндсэн хаяг		Бусад	
Хуулийн этгээдийн холбоо барих мэдээлэл /утас, факс, имэйл/			

## 2. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ

	Нөхөж бичих, эсвэл сонголтуудаас дугуйлна уу	
Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, бүртгэлийн дугаар:	№ .....	
Даатгуулагч нь даатгуулах барилгатай ямар холбоотой	(a) Өмчлөгч, (b) Түрээслэгч, (c) .....	
Барилгыг бусад этгээдэд түрээслүүлдэг бол дэлгэрэнгүй бичнэ үү.		
Даатгуулах барилга нь барьцаанд байгаа эсэх	(a) Үгүй, (b) Тийм .....	
Барилгын зориулалт		
Барилгын байршил (хотын төвд, хотын захад, хороолол дунд гэх мэт)		
Барилгыг ашиглалтанд орсоноос хойш нэмж өөрчилсөн эсэх	(a) Үгүй, (b) Тийм .....	
Одоогийн явуулж буй үйл ажиллагаа		
Материалын хийц	Хана	
	Шал	
	Тааз	
Барисан технологи		
Барилга баригдсан огноо, нас		
Нийт талбайн хэмжээ	.....м2	
Давхарын тоо		
Ойролцоо орших байгууламжуудын нэр, байрлах	Урд талд ....., .....	



зай	метр Хойд талд ....., ....., ....., метр Баруун талаас ....., ....., ....., метр Зүүн талаас ....., ....., ....., .....метр
Залгаа байшин байдаг эсэх	(а) Үгүй, (б) Тийм .....

**3. ДААТГАЛЫН МЭДЭЭЛЭЛ**

		Нөхөж бичих, эсвэл сонголтуудаас дугуйлна уу		
Өмнө нь даатгуулж байсан эсэх		(а) Үгүй, (б) Тийм .....		
Хохирол гарч байсан эсэх		(а) Үгүй, (б) Тийм .....		
Даатгалын байгууллага даатгахаас татгалзаж байсан эсэх		(а) Үгүй, (б) Тийм .....		
Даатгалын компани даатгалын гэрээг цуцлаж байсан эсэх		(а) Үгүй, (б) Тийм .....		
Даатгуулагч хариуцах хэсэгтэй байх эсэх		(а) Тийм /.....төгрөг, хувь; (б) Үгүй		
Даатгалын нийт үнэлгээ				
Даатгалд хамааруулах, үнэлгээ		<i>Зах зээлийн үнэлгээ</i>	<i>Бүртгэлийн үнэ</i>	<i>Сэргээх үнэлгээ</i>
	<i>Барилгыг бүхэлд нь</i>			
	<i>Барилгын ханыг</i>			
	<i>Дагалдах барилгыг</i>			
	<i>Бараа, материал</i>			
	<i>Машин, т.т</i>			
	<i>Тавилга, эд хогшил</i>			
	<i>Бусад .....</i>			
<b>НИЙТ</b>				

**4. ЭРСДЭЛИЙН АСУУЛТУУД**

Сүүлийн 3 жилийн хугацаанд хохирол учирч байсан эсэх	<i>Огноо</i>	<i>Хохирлын шалтгаан</i>	<i>Хохирлын дүн</i>
<b>ҮЕР, УСНЫ ЭРСДЭЛ</b>			
Барилгын сантехникийн системийн үйлдвэрлэгч, үйлдвэрлэсэн улс			
Барилгын сантехникийн системийг үечлэн шалгаж, засвар үйлчилгээг хийдэг үү?			
Ойролцоо үерийн далан, гол горхи байдаг эсэх /урд, хойно, баруун, зүүн/		..... Зай .....м2	
Барилгын хонгилыг ямар зориултаар ашигладаг, ямар нэгэн зүйл хадгалдаг эсэх			
Барилгын сан техникийг тогтмол шалгадаг эсэх			
Усны дохиололын систем байдаг эсэх, байдаг бол үйлдвэрлэгчийн нэр			
Барилга дотор онцгой, аюултай бараа материал			

хадгалдаг эсэх /нэр, тоо хэмжээ/		
<b>ГАЛЫН ЭРСДЭЛ</b>		
Галын хамгаалалтын систем байгаа эсэх	<i>Нэр</i>	<i>Үйлдвэрлэгчийн нэр, тоо ширхэг</i>
	Галын дохиололын систем	
	Галын хор	
	Гидрант	
	Гал унтраагч шүршүүр	
	Гал унтраах хөөс	
	Бусад	
Галын хамгаалалтын системийг тодорхой давтамжтайгаар шалгадаг эсэх		
Барилгад ойр орших гал унтраах ангийн зай		
Барилгад тусгайлан тамхи татах цэг байдаг эсэх		
Барилгад шатамхай хий нөөцлөх танк байдаг эсэх /байдаг бол хаана байрладаг/		
Барилга доторх хог хаягдалын төрөл, байрлал, барилгаас зайлуулах давтамж, зай		
Ажилтнууд галын сургалтанд хамрагдаг эсэх		
<b>ХУЛГАЙНЭРСДЭЛ</b>		
Хамгаалалтын систем	<i>Нэр, зүйл</i>	<i>Тоо ширхэг</i>
	Хяналтын камер	
	Дохиололын систем	
	Хаалганы төмөр хаалт	
	Байнгын харуул хамгаалалт	
	Харуулын байр	
	Бусад	
Байшинг тойрсон битүү хашаа байдаг эсэх		

- Асуулгын хуудас нь бөглөсөн хүний гарын үсэг зурагдснаар байгууллагын тамга тэмдэг дарагдсантай ижил хүчин төгөлдөр гэж үзнэ.
- Барилгын фото зураг /гадна, дотно/-ыг хавсаргах шаардлагатай.

**Үнэн зөв бөглөсөн**

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Овог нэр: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

## 12. НӨХӨН ТӨЛБӨРИЙН МАЯГТЫН ЗАГВАР

Даатгалын гэрээний дугаар: \_\_\_\_\_

Гэрээ эхлэсэн огноо: \_\_\_\_\_ Гэрээ дуусах огноо: \_\_\_\_\_

### ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Даатгуулагчийн нэр .....

Хаяг: .....

Ажлын газар: ..... Албан тушаал: .....

Утас: ..... Имэйл хаяг: .....

Даатгалын брокер, агентын нэр: .....

Хөрөнгийг санхүүгийн гэрээний хүрээнд нэхэмжилж байгаа эсэх:  Тийм  Үгүй

Тийм бол: Санхүүжүүлэгчийн нэр: ..... Гэрээний дугаар: .....

### ХОХИРОЛ/СҮЙРЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Хохирол/сүйрэл болсон огноо: \_\_\_\_\_ Цаг: \_\_\_\_\_

Хохирол/сүйрэл болсон талаар дэлгэрэнгүй тайлбарлана уу (юу, хэрхэн яаж болсон талаар).

.....  
 .....  
 .....

Хохирол/сүйрэлийг хэдийд илэрүүлсэн бэ? Огноо: \_\_\_\_\_ Цаг: \_\_\_\_\_

Хохирол/сүйрэлийн хэлбэр: \_\_\_\_\_

Хохирол/сүйрэл болсон газар, орон: \_\_\_\_\_

Анх хэн олж мэдсэнбэ? \_\_\_\_\_

Цагдаа г.м мэргэжилийн байгууллагад хэзээ мэдэгдсэн бэ? \_\_\_\_\_

Хохиролыг бууруулахад авсан арга хэмжээ \_\_\_\_\_

Гэрчтэй эсэх, тийм бол нэр, утас: \_\_\_\_\_

### НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Нөхөн сэргээх зардалын үнэлгээ: \_\_\_\_\_ MNT

Бодит зардал /ажил хийгдсэн бол/: \_\_\_\_\_ MNT

Нэхэмжилж буй дүн: \_\_\_\_\_ MNT

\*\*Энэхүү маягтын дагуу бидний өгсөн мэдээлэл, тодорхойлолтууд нь бүрэн гүйцэд, үнэн зөв бөгөөд дээр дурьдсан зүйлүүдийг нэхэмжилж байна.

\*Бид энэхүү маягтын дагуу өгсөн мэдээлэл, тодорхойлолтууд нь худал, буруу болон бүрэн бус тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзах, тус өргөдөлийг хүчингүй болгох үндэслэл болно гэдгийг ойлгож байна.

Гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

### 13. НӨХӨН ТӨЛБӨРИЙН МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭЛТ

- ✓ Нөхөн төлбөр олгохыг хүссэн даатгуулагчийн өргөдөл
- ✓ Даатгалын гэрээ, баталгааны эх хувь
- ✓ Хохирол гарсан шалтгаан
- ✓ Хохирол учирсан эд зүйлийн нарийвчилсан бүртгэл
- ✓ Хохиролын үнэлгээ , хохирлын зүйлийг тогтоосон мэргэжилийн байгууллагын акт, материал
- ✓ Хохиролыг нөхөн сэргээх нэхэмжлэл
- ✓ Мэргэжлийн холбогдох байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт
- ✓ Хохирлын байдал, орчинг харуулсан фото зураг

14.СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЗАГВАР

Даатгалын төрлүүд	Барилгын хийц	Байршил	Сантехник	Цахилгаан	Ашигласан жил	Галын хамгаалалт	Харуул хамгаалалт	Байгалийн эрсдлүүд	Галын эрсдлүүд	Сантехникийн эрсдлүүд	Цахилгааны эрсдлүүд	Ахуйн эрсдлүүд	Хулгайн эрсдлүүд	Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлээс үүдэн гарах эрсдэл
1. Орон сууц														
1.1 Амины орон сууц														
1.2 Нийтийн орон сууц														
1.3 Оффис														
2. Үйлчилгээ														
2.1 Зочид буудал														
2.2 Дэлгүүр														
2.3 Ресторан, паб, кафе														
3 Үйлдвэр														
3.1 Хөнгөн үйлдвэр														
3.2 Хүнд үйлдвэр														
3.3 Уул уурхай														
3.4 Агуулах														

## 15. АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

### Эрсдлийн шинжилгээнд тавигдах хяналт ба андеррайтенгийн үр дүн

Даатгагч нь бүтээгдэхүүн (эд хөрөнгийн даатгал эсвэл авто тээврийн хэрэгслийн даатгал гэх мэт)болгоны андеррайтенгийн тохиолдлын талаар сар болгоноор, хагас жилуур эсвэл жилээр гэсэн тодорхой хугацааны завсартайгаар мэдэж байх нь чухал байдаг. Үүний дараа, тогтсон цаг хугацааны завсар бүрд андеррайтенгийн тохиолдлыг хянаж байх нь тухайн бүтээгдэхүүний багц нь андеррайтенгийн ашигтай эсвэл алдагдалтай байгааг даатгагч мэдэж болдог.

Хэрэв бүтээгдэхүүний багц нь андеррайтенгийн алдагдалтай байвал, даатгагч нь тухайн андеррайтенгийн алдагдалд үүсгэж байгаа шалтгааныг мөн, бүтээгдэхүүний багцыг ашигтай байлгахын тулд хамгийн их давамгайлж буй шалтгааныг хянаж түүнийг хөгжүүлэхийг мэдэж байх ёстой.

#### 1. Андеррайтенгийн хохиролын харьцаа:

Тохиолдсон нөхөн төлбөр/орлогод тооцсон хураамж\*100

Энэхүү харьцаа нь сар, хагас жил гэх мэт тодорхой цаг хугацааны давиамжуудад тохиолдсон нөхөн төлбөрийн зардлыг орлогод тооцсон хураамж нь нөхөн олох боломжтой байгаа эсэхийг гаргаж ирнэ.

#### 2. Хохирлын харьцаа: эцсийн(ирээдүйд үлдэх) хохирлын хэмжээ/нийт хураамж\*100

Энэхүү харьцаа нь даатгагчийг нөхөн төлбөрийн үр дүнг жил болгоноор тооцоход тусална. Эцсийн(ирээдүйд үлдэх) хохирол нь тохиолдсон нөхөн төлбөр болон IBNR ийг тооцож тооцоологддог. Хохирол нь онолын үүднээс 60%-иас бага байж байж андеррайтенгийн зардал нь эерэг байна.

#### 3. Нэгдсэн харьцаа: нийт хохирол+маркетинг зардлийг багтаасан зардлууд / нийт хураамж

Нэгдсэн харьцаа нь тухайн бүтээгдэхүүний багц нь ашигтай эсвэл алдагдалтай байгааг мэдэхэд тусална. Хэрэв тухайн бүтээгдэхүүний багцийн нэгдсэн харьцаа нь 100% -иас бага байвал бүтээгдэхүүний багц нь ашигтай байна, хэрэв 100% -иас их байвал бүтээгдэхүүний багц нь алдагдалтай ба бүтээгдэхүүний багц бүр дээр хагас жил эсвэл жилээр цаг хугацааны завсарт хуваан маш сайн хяналт хийж гол шалтгааныг олж мэдэх хэрэгтэй.

#### 4. Андеррайтенгийн зардлын харьцаа

Андеррайтенгийн зардлын харьцаа нь нийт хураамж дахь андеррайтингийн зардлын харьцааг хэлнэ. Андеррайтенгийн зардлын харьцаа нь даатгагчийг гэрээтэй холбоотой гарах зардал зэрэг андеррайтенгийн зардлыг мэдэхэд тусална. Онолын үүднээс, андеррайтенгийн зардлын харьцаа нь 10%-иас бага ба 15%-иас хэтрэхгүй байх нь чухал. Энэхүү андеррайтенгийн зардал нь зууслагчийн хөлс, бизнес хөгжлийн талын маркетингийн менежрүүдэд төлсөн төлбөр гэх мэт маркетингийн зардал ороогүй зардал юм.

5. Үйл ажиллагааны зардлын харьцаа: үйл ажиллагааны зардал/орлогод тооцсон хураамж

Үйл ажиллагааны зардал, цалин зэрэг нь нэгэнт гэрээний хугацааны туршид төлөгдөхөөр тооцоологдсон байдаг. Иймээс үйл ажиллагааны зардал нь орлогод тооцсон хураамжийн хувиар хэмжигдэх ёстой. Үйл ажиллагааны зардал нь онолын үүднээс 15% - 20% -иас бага байх ёстой. Үйл ажиллагааны зардал нь бага байх тусмаа даатгагчийн үйл ажиллагааны давуу байдлыг илтгэдэг.

6. Үлдэгдлийн харьцаа

Үлдэгдлийн харьцаа нь даатгагчийн гэрээний хугацааг сунгах гэрээний тоо юм. Энэ нь өнгөрсөн жилийн гэрээний нийт тооноос шинээр хийх бизнесийн гэрээнүүдийн тоо эсвэл боломжит сунгагдах гэрээний тоог тооцож гаргадаг харьцаа юм. Даатгагчийн авч үлдсэн үйлчлүүлэгчийн тоог мэдэхэд тусалдаг. Онолын үүднээс, сунгагдах гэрээнүүд нь өмнөхөөсөө ижил хураамжийн хувиар сунгуулах эсэх нь чухал. Хэрэв энэхүү харьцаа нь жил ирэх тусам буурч байвал, компани өөрийнхөө үйлчлүүлэгчтэйгээ хандаж байгаа хандлагаадаа анхаарлаа хандуулах хэрэгтэй. Эцэст нь компани үйлчлүүлэгчийн үнэнч байдлыг хадгалснаар зөвхөн маркетингийн зардлыг багасгаад зогсохгүй харин ирээдүйд өргөжүүлэх бизнесдээ илүү өрсөлдөхүйц давуу талыг бий болгоно.

## 16. НӨӨЦ САНГИЙН ТООЦООЛОЛ

Ердийн даатгалын компани нь СЗХ-с гаргасан “Ердийн даатгалын компанийн нөөц сан бүрдүүлэх, зарцуулах” журмын дагуу үндсэн 4 төрлийн нөөцийг бүрдүүлдэг.

1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

Даатгалын хураамжийн орлогын зохих хэсгийг ирээдүйд учирч болзошгүй эрсдэлд зориулж нөөцөлдөг. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан.

- a. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан нь даатгуулагчид ирээдүйд төлөх нөхөн төлбөрийн нөөцийн хэсэг бөгөөд даатгагчийн үйл ажиллагааны зардал үүнд орсон байна.
- b. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг даатгагчийн хүлээн авсан даатгалын хураамжаас гэрээний үлдэх хугацаанд ногдуулан байгуулна.
- c. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг энэ журмын 3. 8-д зааснаас бусад тохиолдолд 8-тын аргаар тооцох бөгөөд улирлын даатгалын цэвэр хураамжийн орлогоос дараах байдлаар тооцно:
  - i.  $ОТХ = ОТХ1 + ОТХ-1 + ОТХ-2 + ОТХ-3$
  - ii.  $ОТХ1 = ЦХ1 * 7/8$
  - iii.  $ОТХ-1 = ЦХ-1 * 5/8$  3.1.  $ОТХ-2 = ЦХ-2 * 3/8$
  - iv.  $ОТХ-3 = ЦХ-3 * 1/8$
- d. Энэ журмын 1.3-т заасан товчлолыг дараах агуулга бүхий тайлбараар тодорхойлж ойлгоно.
  - i. ОТХ- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан;
  - ii. ОТХ1- Тайлант улирлын орлогод тооцоогүй хураамж;
  - iii. ОТХ-1- Тайлант улирлын өмнөх улирлын орлогод тооцоогүй хураамж;
  - iv. ОТХ-2- Тайлант улирлаас 2 улирлын өмнөх орлогод тооцоогүй хураамж;

- v. ОТХ-3- Тайлант улирлаас 3 улирлын өмнөх орлогод тооцоогүй хураамж;
- vi. ЦХ1- Тайлант улирлын цэвэр хураамжийн орлого;
- vii. ЦХ-1- Тайлант улирлын өмнөх улирлын цэвэр хураамжийн орлого;
- viii. ЦХ-2- Тайлант улирлаас 2 улирлын өмнөх цэвэр хураамжийн орлого;
- ix. ЦХ-3- Тайлант улирлаас 3 улирлын өмнөх цэвэр хураамжийн орлого.

2. Учирсан боловч нэхэмжлээгүй /IBNR/ хохирлын нөөц сан

- a. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлант хугацаанд нэхэмжилж болзошгүй хохиролд зориулан байгуулсан нөөц санг ойлгоно.
- b. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц санг тайлангийн жилээс өмнөх үеүдэд байгуулсан гэрээний дагуу даатгуулагчаас нэхэмжилж болзошгүй нөхөн төлбөрийг барагдуулахад зориулан байгуулна. Уг нөөц санг өмнөх санхүүгийн тайлангийн жилүүдийн нөхөн гүйцэтгэлийн хэмжээний талаарх бодит мэдээлэл дээр үндэслэн актуар тооцооллоор орлогод тооцсон хураамжаас санхүүгийн тайлангийн жилийн эцэс бүрт байгуулна.
- c. Тайлант жилээс өмнө байгуулсан даатгалын гэрээний дагуу даатгуулагчаас даатгалын нэхэмжлэл ирсэн тохиолдолдаатгуулагчийн нэхэмжилсэн дүнгээр уг нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан руу шилжүүлнэ.
- d. Даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлэх тохиолдолд төлүүлсэн дүнгээр уг нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- e. Даатгалын тохиолдлын улмаас даатгуулагчийн даатгуулсан хөрөнгө бүрэн сүйрч улмаар даатгагч даатгуулсан хөрөнгийг өөрийн эзэмшил, өмчлөлд авсан тохиолдолд даатгагч уг хөрөнгийг учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангийн хөрөнгөд бүртгэн авна.

3. Нэхэмжилсэн хохирлын нөөц сан

- a. Нэхэмжилсэн хохирлын нөөц сан гэдэгт даатгуулагчийн нэхэмжилсэн хохирлыг нөхөн төлөхөд зориулагдсан нөөц санг ойлгоно.
- b. Нэхэмжилсэн хохирлын нөөц санг даатгуулагчаас даатгалын нэхэмжлэл ирсэн тохиолдолд даатгуулагчийн нэхэмжилсэн дүнгээр учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан эсвэл орлогод тооцсон хураамжийг хорогдуулж байгуулна.
- c. Тайлант хугацаанд байгуулсан гэрээний дагуу даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулна.
- d. Даатгуулагчид олгох даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжилсэн хохирлын нөөц сангаас гаргана.
- e. Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр нэхэмжилсэн хохирлын нөөц сангаас бага байвал зөрүүг нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулсан эх үүсвэр лүү буцаан шилжүүлнэ.

4. Учирч болзошгүй хохирлын нөөц сан

- a. Учирч болзошгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.



- b. Хэлбэр тус бүрийн хувьд даатгуулагчид олгохоор тооцоолсон нөхөн төлбөр нь орлогод тооцоогүй хураамжаас их байх тохиолдолд тэр зөрүүгээр учирч болзошгүй хохирлын нөөц санг орлогод тооцсон хураамжаас байгуулна.
- c. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан болон орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулахад хүрэлцэхгүй болсон тохиолдолд дутсан хэсгийг учирч болзошгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан руу шилжүүлнэ.
- d. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан нь нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд учирч болзошгүй хохирлын нөөц сангаас дутагдсан хэсгийг бүрдүүлэх ба хэрэв учирч болзошгүй хохирлын нөөц сан хүрэлцэхгүй болсон тохиолдолд орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан луу шилжүүлнэ.
- e. Орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэхэд хүрэлцэхгүй болсон тохиолдолд дутагдсан хэсгийг учирч болзошгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан луу шилжүүлнэ.
- f. Энэ журмын 3.1, 3.2-д заасны дагуу нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэх боломжгүй болсон тохиолдолд СЗХ-д мэдэгдэнэ. Учирч болзошгүй хохирлын нөөц сан
- g. Учирч болзошгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.
- h. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд учирч болзошгүй хохирлын нөөцийн санг дараах аргачлалаар улирал тутамд байгуулна. Үүнд:  
ОТХ – аас олгосон нөхөн төлбөр + байгуулсан УБНХНС

$$\text{ОТХ} \diamond * 100\% < X \text{ үед}$$

$$\text{УБНХНС} = \diamond X - \diamond$$

$$\text{ОТХ} - \text{аас олгосон нөхөн төлбөр} + \text{байгуулсан УБНХНС}$$

$$\text{ОТХ} \diamond * 100\% \diamond x$$

Энд,

“ОТХ” – орлогод тооцсон хураамж;

“УБНХНС”- учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан;

“УБХНС” –учирч болзошгүй хохирлын нөөц сан;

“Х” – Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын 3.1.1-д заасан

“Даатгалын цэвэр хураамж”-ийн хувь.

Хэлбэр тус бүрийн хувьд даатгуулагчид олгохоор тооцоолсон нөхөн төлбөр нь орлогод тооцоогүй хураамжаас их байх тохиолдолд тэр зөрүүгээр учирч болзошгүй хохирлын нөөц санг орлогод тооцсон хураамжаас байгуулна.

5. Даатгалын нөөц санд тавих хяналт

- a. Даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд даатгалын бүх нөхөн төлбөр, хураамжийн буцаалт хийгдсэний дараах нөөц сангийн үлдэгдлээс хорооноос томилсон актуарчдын актуар тооцооллын дагуу тохирох хэсгийг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор даатгагчдын холбооны тусгайлсан дансанд байршуулна.
- b. Энэ журмын 5.1-д заасан тусгайлсан дансанд нөөц сангийн мөнгийг 5 жилийн хугацаанд байршуулж, зөвхөн даатгалын нөхөн төлбөрт зарцуулах ба хэрэгжилтэнд хороо байнгын хяналт тавина.
- c. Даатгалын нөөц сангийн хөрөнгийг зөвхөн тухайн сангийн зориулалтын дагуу зарцуулах бөгөөд хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно.
- d. Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд хороо улирал тутам хяналт тавина.
- e. Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг хорооноос зөвшөөрсөн маягтуудын дагуу гаргаж, улирал бүр хороонд ирүүлнэ.
- f. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## 17. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Ашиглах хууль болон эрх зүйн хэм хэмжээнүүд

- Монгол Улсын Үндсэн хууль (1992 он),
- Иргэний хууль, §431-§444 дүгээр зүйлүүд (2002 он)
- Даатгалын тухай Монгол улсын хуулийн бүх зүйл заалтууд (2004 он)
- Холбогдох бусад хууль тогтоомж
- Санхүүний Зохицуулах Хорооноос батласан эрх зүйн актуудыг дагаж мөрдөнө. (Даатгалын тухай хууль §12.1)